

**“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

“Шивээ Овоо” хувьцаат компани нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт оршдог бөгөөд Шивээ-овоогийн хүрэн нүүрсний бүлэг ордын Шинэ-усны хэсэгт “ХЗ” маркийн хүрэн нүүрс олборлодог төрийн өмчит хувьцаат компани юм.

Шивээ-Овоогийн уурхай нь жилд 2.0 сая.тн нүүрс олборлон борлуулах хүчин чадалтай бөгөөд Монгол улсын эрчим хүчний хэрэглээний нүүрсний 30.0%, “ДЦС-4” ТӨХК-ийн нүүрсний хэрэглээний 48.0%-ийг хангаж Говьсүмбэр, Дорноговь, Сэлэнгэ, Төв аймаг болон бусад дотоодын аж ахуй нэгжүүдийн дулаан, цахилгааны станцуудад нүүрсээ нийлүүлж байна.

Компанийн нийт хувьцааны 90%-ийг төр эзэмшдэг, 10%-ийг нь хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. Монгол улсын Засгийн газрын 2013 оны 100 дугаар тогтоолоор “Шивээ Овоо” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг “Эрдэнэс Монгол” төрийн өмчит компанид нэгтгэсэн юм.

НЭГ. УУЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ТАЛААР

Уулын үйлдвэрлэлийг Ашигт малтмал, газрын тосны газраас тогтоон баталсан 2020 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

2020 онд 2,005.0 мян.тн нүүрс олборлон, 2000.7 мян. тн нүүрс борлуулах, 8,838.8 мян.м3 хөрс хуулах үүнээс тээвэртэй 6,686.0 мян.м3, тээвэргүй 2,152.8 мян.м3-ын төлөвлөгөөтэй ажилласан. 2020 оны уулын ажлын гүйцэтгэлээр нүүрс олборлолт 2,007.3 мян.тн, борлуулалт 1,988.6 мян.тн, нийт хөрс 7,841.5 мян.м3 үүнээс тээвэртэй 5,621.5 мян.м3, тээвэргүй 2,219.9 мян.м3 хөрсний ажил тус тус гүйцэтгэсэн байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар складанд 58.7 мян.тн, карьерт авахад бэлэн 40.0 мян.тн, нээгдэхэд бэлэн 50.0 мян.тн нүүрсний нөөцтэй шилжсэн байна.

Уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2019 гүйцэтгэл	2020 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%	Зөрүү
А. Уулын ажлын үзүүлэлт							
1	Нүүрс олборлолт	м.тн	1,992.3	2,005.0	2,007.3	100.1	2.3
2	Нүүрс борлуулалт	м.тн	2,009.8	2,000.7	1,988.6	99.4	(12.1)
3	Тээвэртэй хөрс хуулалт	м.м ³	6,237.6	6,686.0	5,621.6	84.1	(1,064.4)
4	Тээвэргүй хөрс хуулалт	м.м ³	2,336.0	2,152.8	2,220.0	103.1	67.2
5	Дахин шидэлт	м.м ³	2,470.7	2,854.8	3,342.4	117.1	487.6
6	Нийт хөрс хуулалт	м.м ³	8,573.6	8,838.8	7,841.6	88.7	(997.2)
7	Инженер ажил	м.м ³	768.9	620.0	490.1	79.1	(129.9)
8	Нийт уулын цул	м.м ³	13,459.7	13,970.6	13,333.0	95.4	(637.6)

2020 онд 2,005.0 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөснөөс 2,007.3 мян.тн нүүрс олборлож төлөвлөгөөгөө 100.1%, нүүрс борлуулалтыг 1,988.6 мян.тн буюу 99.4 хувийн биелэлттэй ажилласан. 2020 онд гүйцэтгэсэн нийт уулын цулын хэмжээг хувиар авч үзвэл 58.8 хувийг хөрс хуулалт, 25.0 хувийг дахин шидэлт, 3.6 хувийг инженерийн ажил, 18.0 хувийг нүүрс олборлолт эзэлж байна.

Нүүрс борлуулалтын төлөвлөгөөгөөр Налайхын ДС-д 51.7 мян.тн нүүрс нийлүүлэгдэх байсан нь төмөр замын тээврийн асуудлаас нийлүүлэгдээгүй ба “ДЦС-IV” ТӨХК болон бусад хэрэглэгчдийн цахилгаан дулаан үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэнээр оны эцэст 12.89 мян.тн-оор нүүрс борлуулалт тасарсан. 2020 онд одоогийн байгаа технологийн автомашинууд дээр 2019.03.01-нээс 2 ширхэг 55 тн САТ-773 автосамосвал хөрөнгө оруулалтаар худалдан авч, Комацу HD405 – 3

ширхэг, САТ773 – 8 ширхэг, Белаз 7555В /55 тн/ – 6 ширхэг, Белаз 75137 /136 тн/ – 3 ширхэг, нийт 4-н төрлийн 20-н автосамосвалаас ээлжинд тогтмол 18ш ажиллана гэж төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр технологийн автосамосвалуудын найдваргүй ажиллагаанаас шалтгаалан ээлжинд 10-12ш ажилд гарч байсан нь тээвэртэй хөрс хуулалтын ажил тасрах үндэслэл болсон. Технологийн автомашины хүрэлцээгүйн улмаас алхагч экскаваторуудаар тээвэртэйгээр гүйцэтгэх завсрын хөрсийг шидэлт хийж улмаар дотоод овоолгийн шидэлтийг нэмэгдүүлж байна.

ГҮНИЙ УСНЫ ШҮҮРҮҮЛЭЛТИЙН БАЙДАЛ:

Уурхайн үйл ажиллагааг саадгүй явуулахын тулд гүний усны түвшинг нүүрсний давхаргаас доош барих шаардлагатай бөгөөд уурхайн гүн гүнзгийрэх тусам гүний усыг зайлуулахад хүндрэл гарч байна.

2020 онд ус шүүрүүлэх “Д” шугамын төлөвлөгөөнд D23, D24, D25, D26 дугаартай 4 ширхэг цооног 690 уртааш метр, хяналтын 1 ширхэг цооног 150 уртааш метр өрөмдөж монтажлан ашиглалтад оруулахаас ашиглалтын D23 дугаартай 1 ширхэг цооног 188 уртааш метр өрөмдөж монтажлан ашиглалтад оруулсан, гүний худгийн өрмийн машиний засварын сэлбэг хэрэгсэл төлөвлөгдсөн хугацаанаас хойш оройтож ирсний улмаас D24, D25, D26, хяналтын №12 дугаартай ашиглалтын цооногуудыг өрөмдөж, ашиглалтад оруулах боломгүй болсон учраас 2021 онд гүйцэтгэхээр хойшлуулсан. D23-р худгийн салбар шугамын далан, шугам хоолойн хучилт хэлбэршүүлэлтын газар шорооны ажилд 3.0 мян.м³ хөрс орсон байна.

Хяналтын цооногуудын мэдээллээр карьерийн усны түвшинг 3.58 м буулгасан ба карьерт нүүрс олборлолтын ажил гүйцэтгэсэн ашиглалтын 2-р аманд ил зумпфын аргаар насос байрлуулан усны түвшинг 17 м-ээр буулган устай 650.0 мян тн, нийт 730.0 мян тн нүүрсийг усны хүндрэлгүй бүрэн олборлож чадсан.

ӨРӨМДЛӨГ, ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЛААР:

2020 онд нийт 2,390.6 мян.тн энгийн тэсрэх бодис, 168.0 мян.тн эмульсийн тэсрэх бодис хэрэглэж, 196 мян.м³ у/метр өрөмдөн 6,469.1 мян.м³ уулын цулыг тэсэлж сийрэгжүүлэхээр төлөвлөсөн.

2020 оны гүйцэтгэлээр 23,283 ширхэг цооногийг 185.7 мян.м³ у/метр өрөмдөж 6,821 мян.м³ уулын цулыг 86,4 мян.тн эмульсын тэсрэх бодис, 2,232 тн ЭТБ /ANFO/-оо 423 удаагийн тэсэлгээгээр тэсэлж сийрэгжүүлсэн байна. Үүнд:

- Тээвэргүй хөрс хуулалтанд 2,193 ширхэг цооногийг 28,8 мянган уртааш метр өрөмдлөгийн ажил хийж 1,234.5 мянган шоометр уулын цулыг 42 удаагийн тэсэлгээгээр тэсэлж сийрэгжүүлсэн байна.
- Тээвэртэй хөрсөнд 13,533 ширхэг цооногийг 109.2 мянган уртааш метр өрөмдлөгийн ажил хийж 4,181.7 мянган шоометр уулын цулыг 246 удаагийн тэсэлгээгээр тэсэлж сийрэгжүүлсэн байна.
- Нүүрсэнд 7,557 ширхэг цооногийг 47.6 мянган уртааш метр өрөмдлөг хийж 1,344.6 мянган шоометр уулын цулыг 154 удаагийн тэсэлгээгээр тэсэлж сийрэгжүүлсэн байна.

Хөрсөнд 5,392.1 мян.м³ уулын цул тэслэн сийрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 5,476.3 мян.м³ тэсэлж 84.2 мян.м³ илүү гүйцэтгэлтэй байна.

**ХОЁР. ТЕХНИКИЙН ШИНЭЧЛЭЛ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТЕХНИК ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЛААР**

2020 оны байдлаар уурхайн балансад бүртгэлтэй 29 автосамосвал, 21 нэгж машин механизм байна. Үүнээс: 2020 онд ажиллахаар төлөвлөгдсөн техникүүд.

Д.д	Нэрс	Тоо хэмжээ	Ашиглалтын хугацаа дууссан /Дуусах дөхсөн/	
			Машин механизмын тоо	Ашигласан жил
1	Технологийн автомашин	20	7	6-22
2	Гидро экскаватор	4	3	10-21
3	Авто ачигч	3	1	5
4	Бульдозер	5	2	10-21
5	Автогрейдер	3	1	20
6	Зам усалгааны машин	3	2	4-10
Нийт		38	16	

Нийт машин механизм технологийн автосамосвалиудын 62% нь ашиглалтын норм хугацаа дууссан ба дуусах дөхсөн байна. Тухайн онд 9-12 автомашин тогтвортой ажилласан.

Ашиглалтаас хасах нийт техникүүд:

№	Марк	Автомашинны парк №	Ашиглалтан д орсон огноо	Ашиглалтын нормт хугацаа	Ашигласан жил	Техникийн комиссын актын №
1	HD405-6	№05	1999.04.01	10	20	№441
2	HD405-6	№08	1999.04.01	10	20	№183
3	HD405-6	№ 13	1999.3.25	10	20	№ 34
4	HD405-6	№14	1999.3.25	10	20	№394
5	HD405-6	№ 16	1999.3.25	10	20	№462
6	D155A	№03	2003.06.10	12	16	№182
7	WD-600	№01	1999.04.01	10	20	№439
8	3307W-B	№01	2003.08.13	10	14	№467
9	PC200-6Z	№01	1999.04.01	10	21	№151
10	HD405-6	№12	1999.04.01	10	22	№401
11	HD405-6	№15	1999.04.01	10	22	№405
12	D155A	№ 04	2004.09.25	12	17	№403
13	GD825A	№02	2004.09.25	15	17	№404

2020 оны жилийн эцсийн байдлаар уурхайн балансын бүртгэлтэй 11 нэгж үндсэн цахилгаан экскаватор, тэсэлгээний машин механизм байна. Үүнд:

Д.д	Нэрс	Машин механизмын тоо	Ашигласан жил
1.	ЭШ 25/90 алхагч экскаватор	1	17
2.	ЭШ 11/70 алхагч экскаватор	1	6
3.	ЭКГ 10И экскаватор	1	4
4.	ЭКГ5А экскаватор	4	16-29

5.	Тэсэлгээний өрөм	2	2- 21
6.	Хайгуулийн өрөмдлөгийн машин	1	6
7.	Өрөмдлөгийн машин	1	
	Нийт	11	

Нийт цахилгаан экскаваторуудын 60%, тэсэлгээний өрмийн машин DM45E ашиглалтын нормын хугацаа дууссан.

Технологийн тээврийн хэрэгслийн ТББК-ийн талаар

Машин, техник	Тоо/Ш	2020 оны төлөвлөлт		2020 оны гүйцэтгэл	
		ТББК	Тайлбар	ТББК	Тайлбар
Технологийн автомашин HD405 55тн	3	0,35%	20 жил ашигласан техник учир багаар төлөвлөсөн	0.21%	Насжилтаас шалтгаалж, 3 машиныг актлахаар шийдвэр гарган зогсоосон.
Технологийн автомашин CAT773 55тн	8	0,85%		0.85%	
Технологийн автомашин БеЛАЗ 7555В 55тн	6	0,55%	Эвдрэл гэмтэл ихтэй учир багаар төлөвлөсөн	0.34%	сэлбэг хэрэгслийн зардал ихсэж, ажлын бүтээл буурсан учир 4 машиныг ажиллуулахгүйгээр зогсоон.
Технологийн автомашин БеЛАЗ 75137 136тн	3	0,70%	Хөдөлгүүр засварын хугацаа болсон учраас 70 хувь төлөвлөсөн	0.46%	хөдөлгүүрийн эд ангийн эвдрэл, саатлаар БелАЗ №02 автосамосвал 2500 цаг, №03 автосамосвал 5200 цаг зогссон.
Технологийн автомашин HD 465 55тн	5	98%	7 сарын 1-ээс ажилуулж эхлэхээр бизнес төлөвлөгөөнд тусгасан.	0.99%	2 машин 11 сарын 20-оос, 3 машин 12 сарын 16-аас ажилласан.
ДҮН	25	0.78%		0.73%	

ТББК-ийг 2019 оны ТББК-тай харьцуулж, өсөлтийг үзвэл:

Машин, техник	2019 оны жилийн дундаж	2020 оны жилийн дундаж
---------------	------------------------	------------------------

Нэр	ТББК	ТАК	ТББК	ТАК
Технологийн автомашин	0.69	0.67	0.73	0.72
Хүнд машин механизм	0.66	0.65	0.65	0.64
Өрмийн машин	0.57	0.56	0.80	0.80
Цахилгаан экскаватор	0.91	0.75	0.94	0.74
Алхагч экскаватор	0.79	0.77	0.80	0.79
ДҮН	0.70	0.67	0.73	0.69

- 2020 онд ТББК-73%, ТАК-69%-тай байгаа нь дараах хүчин зүйлсээс нөлөөлсөн.
- Нийт машин механизмуудын 62% нь насжилт өндөр байгаа нь техникийн ашиглалтын коэффициент сөрөгөөр нөлөөлж байгаа гол шалтгаан болж байна.
- Томоохон сэлбэг материалын ханган нийлүүлэлт ковид-19 цар тахал улмаас худалдан авалтын нийлүүлэлтийн хүндрэлээс шалтгаалан удааширсан.
- Дээрх шалтгаанууд болон технологийн автомашины дутагдалтай байдал нь оны эхнээс төлөвлөсөн тээвэртэй хөрс хуулалтын ажил 1.064.456 мян.м³-ээр тасалдахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

Техникийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

1. Одоо ашиглаж байгаа насжилт өндөртэй ашиглалтын зардал нэмэгдэж буй “Комацу” техникүүд болон Shacman, БелА37555В автосамосвалиудыг актлах санал гаргаад, нэг төрлийн өндөр бүтээл бүхий брендийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдээр техникийн шинэчлэл хийх бодлогыг баримтлан ажиллаж байна.

2. Парк бүрдүүлэлтийг нүүрсний пластын зузаан, завсарын хөрсний үеүдийн зузаанд тохируулан 5,6м³ гидроэкскаватор, 50-60 тн автосамосвал ажиллуулах, мөн үндсэн хөрс хуулалтанд 136 тн-оос дээш даацтай автосамосвал түүнтэй хосолж ажиллах “ЭКГ-10И” экскаваторт шилжүүлэх бодлогыг баримталж байна.

“Шивээ-Овоо” ХК нь 2020 онд хөрөнгө оруулалт техник зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын хүрээнд санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдалд ажиллаж байгаа ч компанийн өөрийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан 12 төрлийн техник, автомашин худалдан авч техникийн баазад шинэчлэлт хийлээ. Үүнд:

Техникийн шинэчлэлийн хүрээнд:

1. 04 сарын 08-нд “УРАЛ” маркийн хүн тээврийн зориулалт бүхий 30 хүний суудалтай автобус 2-ийг 458 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтанд оруулсан.

2. 10 сарын 02-нд “TEREX TR60W” маркийн 1 усны машиныг 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтанд оруулсан.

3. 12 сарын 07-нд уул уурхай, карьерийн зориулалттай үйлчилгээний автомашин 3 ширхэгийг 337.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулсан.

5. 12 сарын 13-нд “КОМАЦУ HD465” маркийн 5 ширхэг технологийн автомашинуудыг “JBIC”төслийн хөрөнгө оруулалтаар ашиглалтанд оруулсан.

6. 12 сарын 16-нд “КОМАЦУ РС1250” маркийн 1 ширхэг гидроэкскаватор “JBIC”төслийн хөрөнгө оруулалтаар ашиглалтанд оруулсан байна.

2020 онд нийт 2,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

ГУРАВ. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

2020 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛБАР БИЧИГ

2020 онд 2,005.0 мянган тонн нүүрс олборлон, 2000,7 мянган тонн нүүрс борлуулах, 8,838.8 мянган м3 хөрс хуулах төлөвлөгөөтэй ажилласнаас нүүрс олборлолт 2,007.3 мянган тонн, борлуулалтын хэмжээ 1,988.6 мянган тонн болж төлөвлөгөө 99.4-100.1 хувийн, хөрс хуулалтын хэмжээ 7,841.6 мянган м3 болж төлөвлөгөө 88.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Хөрс хуулалтын ажлыг дотор нь салгаж үзвэл тээвэртэй хөрс хуулалт 5,621.6 мянган м3 буюу 84.1 хувь, тээвэргүй хөрс хуулалт 2,220 мянган м3 буюу 103.1 хувийн биелэлттэй ажилласан байна.

Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд:

Д/д	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2019 гүйцэтгэл	2020 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%	Зөрүү
А. Уулын ажлын үзүүлэлт							
1	Нүүрс олборлолт	м.тн	1,992.3	2,005.0	2,007.3	100.1	2.3
2	Нүүрс борлуулалт	м.тн	2,009.8	2,000.7	1,988.6	99.4	(12.1)
3	Тээвэртэй хөрс хуулалт	м.м ³	6,237.6	6,686.0	5,621.6	84.1	(1,064.4)
4	Тээвэргүй хөрс хуулалт	м.м ³	2,336.0	2,152.8	2,220.0	103.1	67.2
5	Дахин шидэлт	м.м ³	2,470.7	2,854.8	3,342.4	117.1	487.6
6	Нийт хөрс хуулалт	м.м³	8,573.6	8,838.8	7,841.6	88.7	(997.2)
7	Инженер ажил	м.м ³	768.9	620.0	490.1	79.1	(129.9)
8	Нийт уулын цул	м.м³	13,459.7	13,970.6	13,333.0	95.4	(637.6)

Тээвэртэй хөрс хуулалт тасарсан шалтгаан нь 2020 оны уулын ажлын төлөвлөгөөнд 18 ширхэг технологийн автомашин ажиллана гэж төлөвлөсөн боловч технологийн автосамосвалуудын найдваргүй ажиллагаанаас шалтгаалан ээлжинд 8-12 ш автосамасвол ажилласантай холбоотой.

Технологийн автомашины хүрэлцээгүй улмаас алхагч экскаваторуудаар тээвэртэйгээр гүйцэтгэх завсрын хөрсийг шидэлт хийх замаар дотоод овоолгийн дахин шидэлтийг нэмэгдүүлж байна.

Шулуун конвейерийн анхны хөрөнгө оруулалтаар тавигдсан ремен хуучирч, элэгдэл ихтэй байгаа нь тасрах, хий эргэх зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж шулуун конвейерийн бүтээл буурсан.

- Нүүрс борлуулалтын хэмжээ төлөвлөснөөс 12.1 мянган тонноор, өнгөрсөн оны мөн үеийнхээс 21.2 мянган тонноор бага борлуулалт хийсэн байна. 2019 онд 60,909.8 сая төгрөгийн зардал гаргаж олборлолтын нэгжийн өртөг 30,573.1 төгрөг байсан.
- 2020 онд 1 тонн нүүрсний үнийг 2019 оны 7 сарын 9-ний өдрөөс 2000 төгрөгөөр нэмэгдүүлж **29,060.00** төгрөг болгосон.
- Гэтэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 1 тн нүүрсний бодит өртөг **31,228** төгрөгт хүрсэн. Эндээс 1 тонн тутамд **2,168** төгрөгийн алдагдал хүлээж байгаа учраас техникийн шинэчлэл хийх мөнгөн хөрөнгийн хомсдолтой байна.

НЭГ. НҮҮРС БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТАЛААР

2020 онд 1,988.6 мянган тонн нүүрс борлуулж нүүрс борлуулалтын төлөвлөгөөг 0.6 хувь буюу 12.1 мянган тонноор дутуу гүйцэтгэсэн байна. 2020 онд борлуулалтаас 57,756.3 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 57,710.4 сая төгрөгийн орлого олж 99.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байгаа нь 1 тонн нүүрсний нэгжийн үнийг 2020.07.01-нээс 3,000.0 төгрөгөөр нэмэгдүүлж 32,060.0 төгрөг болохоор төлөвлөсөн боловч цаг үеийн байдлаас шалтгаалж нүүрсний үнийг нэмэгдүүлэх боломжгүй болсон.

“ДЦС-IV” компанид нийлүүлсэн нүүрсний жилийн дундаж илчлэг 3,012.8 ккал/кг болж стандартаас /3000 ккал.кг/ их байснаар илчлэгийн зөрүүний ашиг 241.8 сая төгрөг болж байна. Олборлосон нүүрсний илчлэг 2020 оны 1-р улирлын байдлаар 3,259.0 ккал/кг, 2-р улиралд 3,025.0 ккал/кг, 3-р улиралд 3,054.7 ккал/кг, 4-р улиралд 3,012.7 ккал/кг гарч дундаж илчлэг өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,23 ккал/кг-аар нэмэгдсэн байна. Нүүрс борлуулалтын зах зээлийн томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй нүүрсний хэмжээг үзүүлбэл /мянган тонноор/:

Нийт нүүрснийхээ 96.2 хувийг доорх 8 хэрэглэгчид борлуулсан байна.

Д,д	Хэрэглэгчид	Хэм нэгж	2019 оны гүйц	2020 оны төлөв	2020 оны гүйц	Хувийн жин	2020 гүйц/ 2020 төлөв
1	ДЦС-4 ТӨХК	м.тн	1,655.0	1655	1670.677	84.01	100.9
2	Амгалан ДС	м.тн	95.5	105.6	102.4206	5.15	97.0
3	ДЦС-2 ТӨХК	м.тн	19.2	0	0	-	0.0
4	Налайх ДС	м.тн	34.3	51.7	0.334	0.02	0.6
5	УБТЗ ХНН	м.тн	36.0	43	46.18	2.32	107.4
6	Чандмань илч ХХК	м.тн	33.3	37.5	37.725	1.90	100.6
7	Бор өндөр УБҮ	м.тн	38.0	44.5	36.79315	1.85	82.7
8	Чандмань бадрал ХХК	м.тн	17.2	2.3	18.285	0.92	795.0
9	Бусад	м.тн	81.4	61.05	76.135	3.83	124.7
Нийт дүн		м.тн	2,009.9	2,000.7	1,988.6	100.0	99.4

2020 онд манай нүүрс борлуулалтын зах зээлд шинэ хэрэглэгч нэмэгдээгүй ч ДЦС-4 ТӨХК, УБТЗ, Чандмань илч болон Чандмань бадрал ХХК-д нийлүүлсэн нүүрсний гүйцэтгэл төлөвлөгөөг давуулан биелүүлсэн нь үйл ажиллагааны гол үр дүн байлаа.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ЗАДАРГАА			
Д,д	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС	Хэмжих нэгж	Зардлын дүн
1	Материалын орлого	м.төг	4,241.7
2	Үндсэн хөрөнгө ашиглалтаас хассаны олз	м.төг	32,720.9
3	Хүүгийн орлого	м.төг	4,086.2
4	Дулааны орлого	м.төг	64,356.5
5	Пүүний орлого	м.төг	20,345.2
6	Бусад орлого	м.төг	37,990.0
7	Түрээсийн орлого	м.төг	1,090.9
8	Засварын орлого	м.төг	4,683.8
9	Сайтын урамшуулал	м.төг	1,090.9
	Түлшний орлого	м.төг	11,459.0
Нийт дүн		м.төг	182,065.3

Материалын орлогод түлш, тос, бензин болон бочек борлуулсны орлого хамаарна. Бусад орлогод цахим тендерийн үнэ, тээврийн хөлс, орон сууцны хөлс, буцаалт зэрэг орлогууд хамаарна.

ХОЁР. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨРТӨГ ЗАРДЛЫН ТАЛААР

2020 онд гүйцэтгэлээр нүүрс борлуулалтын нийт зардал төлөвлөсөн хэмжээнээс 3.8 хувь буюу 2.3 тэрбум төгрөгөөр, өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.7 хувь буюу 2.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар 1 тн нүүрсний бодит өртөг **31,228** төгрөгт хүрч, 29,020.6 төгрөгөөр борлууллаа.

Техник-эдийн засгийн үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв.

"ШИВЭЭ-ОВОО" ХК-ИЙН 2020 ОНЫ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 он		Харьцуулалт %	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төл-тэй	Өнгөрсөн онтой
I Эдийн засгийн үзүүлэлт							
1	Нүүрс олборлолт	м.тн	1,992.3	2,005.0	2,007.3	100.1	100.8
	Нүүрс борлуулалт	м.тн	2,009.8	2,000.7	1,988.6	99.4	98.9
	Хөрс хуулалт	м.м³	8,573.6	8,838.8	7,841.6	88.7	91.5
	Нийт уулын цул	м.м³	13,459.7	13,970.6	13,333.0	95.4	99.1
2	Нийт орлого:	м.төг	55,885,721.6	57,941,289	57,892,474.6	99.9	103.6
	Үүнээс Цэвэр борлуулалт	м.төг	55,673,599.5	57,756,259	57,710,409.3	99.9	103.7
3	Нийт зардал:	м.төг	63,348,063.9	62,660,182.3	60,196,778.3	96.1	95.0
	Үүнээс: Удирдлагын	м.төг	549,058.4	758,750	748,510.8	98.7	136.3
	Нийт өртөг	м.төг	63,348,063.9	62,660,182.3	60,196,778.3	96.1	95.0
4	Татварын өмнөх ашиг(алдагдал)	м.төг	(7,462,342.3)	(4,718,893.3)	(2,304,303.8)	48.8	30.9
5	Төсвийн төлбөрт:	м.төг	9,270,337.9	9,780,737.9	9,557,964.4	97.7	103.1
	Үүнээс: а) Орлогын татварт	м.төг	2,087.7	-	408.6	#DIV/0!	19.6
	б) НӨАТ	м.төг	5,567,360.0	5,775,628.9	5,771,040.9	99.9	103.7
	в) Бусад татварт	м.төг	3,700,890.3	4,005,109.0	3,786,514.8	94.5	102.3
6	Нийт авлага	м.төг	4,371,642.4	3,532,900.0	2,843,249.5	80.5	65.0
7	Нийт өглөг	м.төг	120,124,757.5	127,713,400.9	127,956,604.9	100.2	106.5
	Үүнээс богино хугацаат өглөг	м.төг	51,482,099.6	42,997,867	52,212,179.9	121.4	101.4
8	Сарын дундаж цалин	м.төг	1,741.6	1,842.7	1,907.9	103.5	109.5
9	1 тн нүүрсний өртөг	төг	30,573.1	31,921.8	31,228.0	97.8	102.1
10	1 тн нүүрсний дундаж үнэ	төг	27,701.0	30,417.0	30,400.0	99.9	109.7
11	1 м³ уулын цулын өртөг	төг	4,525.4	4,359.6	4,396.0	100.8	97.1
12	Нийт цалингийн сан	м.төг	11,557,306.0	12,869,387.8	12,798,472.7	99.4	110.7
13	Ажилчдын тоо	хүн	553	582	559	96.0	101.1
14	Бор-ын 1 төг-т ногдох зардал	төг	1.09	0.90	1.00	111.1	91.7
15	Хөдөлмөрийн бүтээмж орлогоор	м.төг	100,675.6	99,237.6	103,238.70	104.0	102.5
16	Хөдөлмөрийн бүтээмж ажлаар	м.мЗ	24.3	24.0	23.90	99.6	98.4
II Түлш эрчим хүчний найдвартай байдал							
1	Аваар, осол /техникийн/	тоо	-	-	-	#DIV/0!	#DIV/0!
2	Хөрс хуулалтын коэффициент	м³/тн	4.3	4.4	3.9	88.5	90.7
3	Ус шүүрүүлэлт	м.куб	3,980.0	4,044.7	2,632.1	65.1	66.1
4	Нөхөн сэргээлтийн зардал	м.төг	49,742.4	125,000.0	49,580.0	39.7	99.7

Нүүрсний өөрийн өртгийг бүрдүүлж буй нийт зардлаас 9 нэр төрлийн зардал 4,898.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн, 15 нэр төрлийн зардал 2,832.3 сая төгрөгөөр хэтэрсэн үзүүлэлттэй гарч, үйлдвэрлэлийн зардлуудыг төлөвлөгөө болон өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзвэл:

а) Хэтэрсэн зардлуудыг авч үзвэл:

1. Тээлгээний зардал 1 хувь буюу 45.3 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь өрмийн машины сэлбэгийн зардал төлөвлөгөөгөөр 254.1 сая төгрөг гүйцэтгэлээр 312.3 сая төгрөг гарсантай, анфо тэсрэх материалын нэгжийн өртгийг тооцоходоо өрмийн машины элэгдэл болон тээлгээний хэсгийн ажилтнуудын цалин хөлсний зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, элэгдлийн зардлыг тус тус шингээж байгаатай холбоотойгоор 45.3 сая төгрөгийн зардал гарсантай тус тус холбоотой.

2. Вагон ашиглалтын зардал 3 хувь буюу 7.6 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь УБТЗ-ийн гэрээний дагуу АТҮЦС программын багцын төлбөр, 2 хүний хүлээлгийн санамж нийлээд 10.9 сая төгрөг гарсантай тус тус холбоотой.

3. Сэлбэг хэрэгслийн зардал 4.2 хувь буюу 335.4 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Автобульдозерийн хэсгийн их засварын ажил болох 1.4 тэрбум төгрөгний зардал гараагүй боловч, бизнес төлөвлөгөөний тодотголоор зайлшгүй шаардлагаар эвдрэлтэй техник ажилд оруулахын тулд 1.7 тэрбум төгрөгний сэлбэг зарцуулсантай холбоотой.

4. Хөдөлмөр хамгааллын зардал төлөвлөсөн хэмжээнээс 17.1 хувь буюу 119.5 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь COVID-19 цар тахал гарсантай холбоотойгоор амны хаалт гар ариутгагчийн зарцуулалттай холбоотой.

5. Нийгмийн даатгалын шимтгэл төлөвлөсөн хэмжээнээс 5.3 хувь буюу 91.5 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь төлөвлөгөөнд байгууллагаас төлөх шимтгэлийг 14 хувиар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр тус шимтгэлийг 14.5 хувиар тооцсонтой холбоотой.

6. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 11.5 хувь буюу 960.9 сая төгрөгөөр өссөн шалтгаан нь САТ-773 технологийн автомашинууд, ДМ30Е өрмийн машины элэгдэл байгуулсантай холбоотой.

7. Зээлийн хүүний зардал 83.2 хувь буюу 478.4 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь “Эрдэнэс Монгол” ХХК-иас авсан зээлийн 2018-2019 оны хүүний төлбөр 2020 онд тусгагдаж, тус компаниас авсан 5.5 тэрбум төгрөгийн зээлийн хүүний төлбөр 409.0 сая төгрөг, **“Транс Техно Маркет” ХХК-аас авсан бульдозерын төлбөрийн хүүний үлдэгдэл 138.4 сая төгрөг** зэрэгтэй холбоотой.

8. Борлуулалт маркетингийн зардал нь “Эрдэнэс Монгол” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу менежментийн төлбөр тооцож байгаатай холбоотой.

б) Хэмнэгдсэн зардлуудыг авч үзвэл:

1. Дизель түлшний зардал 6.7 хувь буюу 541.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн шалтгаан нь нэгжийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 595.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн бол $(1,593 \text{ төг төлөв} - 1,477 \text{ төг гүйц}) = -116 \text{ төг} * 5,133.8 \text{ м.литр/}$, биет хэмжээний зарцуулалтаас шалтгаалж 48.3 сая төгрөгөөр хэтэрсэнтэй $(5,133.8 \text{ м.литр гүйц} - 5,101.1 \text{ м.литр гүйц}) = 32.7 \text{ м.литр} * 1,477 \text{ төг/}$ холбоотой. Дизель түлш биетээр өссөн шалтгаан нь 2020 оны сүүлээр 10 дугаар сарын дундаас эхлэн ээлж дараалан Коматцу HD465 автосамосвал 60 тонны 5 ширхэгийг ажил гүйцэтгүүлж, 6.7 м³ шанагатай, өндөр бүтээлтэй РС-1250 гидро экскаватор ажиллуулж эхэлсэнээр дизель түлшний зарцуулалт 0.6 хувь буюу 32.7 мянган литрээр нэмэгдсэн байна.

2. Тос, тослох материалын зардал 13.6 хувь буюу 145.1 сая төгрөгөөр хэмнэсэн шалтгаан нь нэгжийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 14.8 сая төгрөгөөр $(7634.3 \text{ төг төлөв} - 7516.1 \text{ төг гүйц}) = 118.2 \text{ төг} * 125,173.7 \text{ л/}$, биет хэмжээний зарцуулалтаас шалтгаалж 128,3 сая төгрөгөөр $(142,243.2 \text{ л төлөв} - 125,173.7 \text{ л гүйц}) = 17069.5 * 7516.1 \text{ төг/}$ тус тус хэмнэсэнтэй холбоотой.

3. Цахилгаан эрчим хүчний зардал 16.5 хувь буюу 686.1 сая төгрөгөөр хэмнэсэн шалтгаан нь цахилгаан эрчим хүчний хэмнэлтийн жил болгон зарласантай холбоотойгоор оргил ачааллын үед экскаваторуудыг зогсоож тосолгоо үйлчилгээ хийж оргил ачааллын үеийн цахилгаан эрчим хүчний өндөр тарифтай цагуудад зогсоосоноор үнийн дүнгээр хэмнэх шалтгаан болсон.

Мөн ус шүүрүүлэхийн 34 цооногуудад 11-16 кВт-ын хүчин чадалтай хөдөлгүүр насосууд 22 кВт-ын хүчин чадалтай хөдөлгүүр насосууд ажиллуулсан, 1250 кВт-ын ачаалалтай ажилладаг ЭШ-11/70 алхагч экскаватор, 2500 кВт-ын ачаалалтай ажилладаг ЭШ25/90 алхагч экскаваторууд төлөвлөгөөнөөс 3.1 хувь буюу 67.2 мянган шоометрээр илүү тээвэргүй хөрс хуулалт хийж, 17.1 хувь буюу 487.6 мянган шоометрээр илүү дахин шидэлт хийсэн, өвлийн улиралд технологи дамжлагын бункерт нүүрс хахалт өндөр байж цахилгаан эрчим хүчний ачаалал нэмэгдсэнээр цахилгаан эрчим хүч биетээр 593.9 мянган кВт-аар өсөх шалтгаан болсон.

4. Дулааны зардал 53 хувь буюу 46.5 сая төгрөгөөр хэмнэсэн шалтгаан нь биет хэмжээний зарцуулалтаас шалтгаалж $2,626 \text{ тн төлөв} - 1,761.3 \text{ тн гүйц} = 864.7 \text{ тн} * 24,627.1 \text{ төгрөг/}$ 21.3 сая төгрөгөөр хэтэрсэн ч, нэгжийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалж $33,418.0 \text{ төг төлөв} - 24,627.1 \text{ төг гүйц} = 8,790.9 \text{ төг} * 1,761.3 \text{ тн/}$ 15.5 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой.

5. Дугуйны зардал 35.8 хувь буюу 719.3 сая төгрөгөөр хэмнэсэн шалтгаан нь “COVID-19” цар тахалын улмаас шинэ сэлбэг, дугуйны нийлүүлэлт удааширнаар тогтоосон норм давуулж

ажилласан. Мөнгөн дүнгээр 719.3 сая.төг /төлөв 2,007.7 сая төг – гүйц 1,288.5 сая төг = 719.3 сая төг/, биет хэмжээгээр 172 – 138 = 34 ш дугуй хэмнэж ажилласан.

6. Цалин хөлсний зардал 3.0 хувь буюу 376.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн шалтгаан нь бүтээлийн цалин төлөвлөгөөгөөр 2911.4 сая төгрөг гүйцэтгэлээр 2215.5 сая төгрөг гарч 695.9 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

7. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 5.2 хувь буюу 78.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн шалтгаан нь борлуулалтын орлого 0.1 хувь буюу 45.9 сая төгрөгөөр буурсантай холбоотой. Борлуулалтын орлогын 2.5 хувиар АМНАТ тооцно.

8. Ус ашигласны төлбөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, газрын төлбөр болон авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар 31.0 хувь буюу 231.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн шалтгаан нь шүүрүүлсэн усны хэмжээ гүйцэтгэлээр 65.1 хувь, 1412.6 мянган шоометрээр буурсантай холбоотой.

9. Даатгалын зардал 21.8 хувь буюу 54.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн шалтгаан нь нээлттэй сонгон шалгаруулалтаар төлөвлөсөн үнээс бага үнийн саналаар даатгалын компани шалгарсантай холбоотой.

10. Нөхөн сэргээлтийн зардал 60.3 хувь буюу 75.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн шалтгаан нь Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэж тайлан гаргах ажил үргэлжилж байгаатай, ус шүүрүүлэхийн усны хаялбарын шуудууг бетондох, 2 га талбайд нөхөн сэргээлт хийх ажил болон 30 жилийн ойд зориулан орон нутагтаа Ногоон байгууламж цэцэрлэгт хүрээлэн бий болгох ажлууд санхүүгийн хүндрэлээс шалтгаалж хийгдээгүйтэй тус тус холбоотой.

11. Албан томилолтын зардал 82.4 хувь буюу 123.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь ковид-19 холбоотойгоор албан томилолтоор бус цахим сүлжээгээр ажилласантай холбоотой байна.

12. Сургалтын зардал 44.3 хувь буюу 44.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн шалтгаан нь төлөвлөсөн сургалтуудыг төсөвт өртгөөс бага дүнгээр хийж гүйцэтгэсэнтэй, хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх, “COVID-19” цар тахал гарсантай холбоотой.

13. Харуул хамгаалалтын зардал 2.8 хувь буюу 4.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн шалтгаан нь нээлттэй сонгон шалгаруулалтаар төлөвлөсөн үнээс бага үнийн саналаар харуул хамгаалалтын компани шалгарсантай холбоотой.

14. Ажлын хөлсний зардал 14.9 хувь буюу 364.3 сая төгрөгөөр буурсан шалтгаантай.

15. Бусад зардал 7.9 хувь буюу 28.9 сая төгрөгөөр буурсан нь төлөвлөснөөс бичиг хэрэг 12.5 сая төгрөгөөр, зээлийн шимтгэл 25.1 сая төгрөгөөр, аудитын ажлын хөлс 30.6 сая төгрөгөөр, гишүүн байгууллагын татвар, УБТГ зардал 10.4 сая төгрөгөөр буурсан зэрэгтэй холбоотой.

16. Магадлашгүй зардал 250.0 сая төгрөгөөр, урсгал засварын зардал 143.9 сая төгрөгөөр, 30 жилийн ойн зардал 182.7 сая төгрөгөөр, техникийн бэлэн байдлыг хангах зардал 700.0 сая төгрөгөөр нийт дүнгээрээ 1276.6 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

17. Удирдлагын зардлын төлөвлөгөөнд тусгагдсанаар тус зардлын дүнд удирдлагын багийн цалин, нийгмийн даатгалын шимтгэл болон удирдлагын багийн автомашины шатахуун, сэлбэгийн зардал, Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлууд багтдаг, гүйцэтгэлээр 1.4 хувь буюу 10.3 сая төгрөгөөр хэмнэсэн шалтгаан нь цалин НДШ 16.5 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой.

Алдагдлын шалтгаан нь

2020 онд борлуулалтын орлого төлөвлөснөөс 45.9 сая төгрөгөөр тасарч, тээвэртэй хөрс хуулалт 1064.4 мянган шоометрээр тасарч уулын цулын ажил нийт дүнгээрээ 637.6 мянган шоометрээр

төлөвлөгөөнөөс буурч, зардал төлөвлөгөөнөөс цэвэр дүнгээрээ 2.4 тэрбум төгрөгөөр буурсан зэрэгтэй холбоотойгоор 2.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан.

Үйлдвэрлэлийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлэв.

Д/д	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2019 гүйцэтгэл	2020 он				
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%	Зөрүү	
В. Зардлын үзүүлдэлт								
1	Тээлгээ	м.төг	4,435,536.4	4,734,293.3	4,779,650.7	101.0	45,357.4	
2	Дизелийн түлш	м.төг	10,062,090.4	8,125,384.7	7,584,306.8	93.3	(541,077.9)	
3	Бензин	м.төг	112,106.0	97,103.5	97,103.5	100.0	(0.0)	
4	Тос, тослох материал	м.төг	999,369.4	1,085,920.2	940,816.5	86.6	(145,103.8)	
5	Ашиглалтын зардал	Цахилгаан эрчим хүч	м.төг	3,417,525.1	4,156,280.5	3,470,224.6	83.5	(686,055.9)
		Дулаан	м.төг	108,337.3	87,755.7	41,222.8	47.0	(46,532.8)
		Цэвэр бохир ус	м.төг	79,645.5	-	81,005.0	#DIV/0!	81,005.0
6	Вагон ашиглалт	м.төг	275,626.6	258,684.6	266,329.6	103.0	7,645.0	
7	Дугуй	м.төг	960,926.8	2,007,740.0	1,288,453.5	64.2	(719,286.5)	
8	Сэлбэг хэрэгсэл	м.төг	9,564,804.8	8,000,000.0	8,335,388.0	104.2	335,388.0	
9	Хөдөлмөр хамгаалал	м.төг	759,898.7	700,000.0	819,576.6	117.1	119,576.6	
10	Цалин хөлс	м.төг	11,136,579.4	12,344,282.7	11,968,084.8	97.0	(376,197.9)	
11	НДШ	м.төг	1,715,399.5	1,728,199.6	1,819,744.7	105.3	91,545.1	
12	Татварын зардал	Ашигт малтмалын төлбөр	м.төг	1,388,829.6	1,521,344.7	1,442,760.2	94.8	(78,584.5)
		УАТ, ҮХХАТ, АТӨЯХ	м.төг	596,661.2	752,395.2	517,092.6	68.7	(235,302.7)
		Газрын татвар	м.төг	-	3,169.5	6,258.0	197.4	3,088.5
		Тусгай зөвшөөрлийн төлбөр	м.төг	-	-	659.3	#DIV/0!	659.3
13	Үндсэн хөрөнгийн элэгдэл	м.төг	8,375,981.2	8,390,482.4	9,351,420.1	111.5	960,937.6	
14	Зээлийн хүү	м.төг	1,132,195.8	575,104.2	1,053,555.5	183.2	478,451.3	
15	Хөрс хуулалтын хойшлох зардал	м.төг	-	-	-	#DIV/0!	-	
16	Даатгалын зардал	м.төг	257,493.5	261,541.9	206,845.3	79.1	(54,696.6)	
17	Нөхөн сэргээлтийн зардал	м.төг	49,742.4	125,000.0	49,580.0	39.7	(75,420.0)	
18	Гэрээт ажлын хөлс	м.төг	2,634,295.1	2,443,256.7	2,078,924.7	85.1	(364,332.0)	
19	Албан томилолт	м.төг	146,203.7	150,000.0	26,370.0	17.6	(123,630.0)	
20	Сургалт	м.төг	65,808.3	101,030.0	56,224.5	55.7	(44,805.5)	
21	Лицензийн гүрээс	м.төг	224,400.0	224,400.0	224,400.0	100.0	-	
22	Харуул хамгаалалт	м.төг	160,339.9	174,000.0	169,099.0	97.2	(4,901.0)	
23	Хөрөнгө оруулалтын зардал	м.төг	-	-	-	#DIV/0!	-	
24	Борлуулалт маркетингийн зардал	м.төг	635,103.1	39,134.2	650,232.2	1,661.5	611,098.0	
25	Бусад зардал	Бичиг хэрэг	м.төг	88,902.2	67,354.1	54,881.8	81.5	(12,472.2)
		Харилцаа холбоо	м.төг	31,519.7	33,330.0	34,343.3	103.0	1,013.3
		Мэдээллийн Технологи	м.төг	-	150,000.0	158,480.2	105.7	8,480.2
		Зээлийн шимтгэл 1%	м.төг	-	50,000.0	24,928.7	49.9	(25,071.3)
		Аудит	м.төг	19,200.0	50,000.0	19,440.0	38.9	(30,560.0)
		Гишүүн байгууллагын татвар	м.төг	3,000.0	4,000.0	3,001.2	75.0	(998.8)
		УБТГ	м.төг	1,462.2	12,000.0	2,555.4	21.3	(9,444.6)
Бусад татвар хураамж	м.төг	28,234.6	-	40,137.2	#DIV/0!	40,137.2		
27	Магадлашгүй зардал	м.төг	-	250,000.0	-	-	(250,000.0)	
28	Урсгал засварын зардал /Хангамжийн материал	м.төг	378,356.3	344,181.7	200,264.4	58.2	(143,917.3)	
29	Орон сууцгай холбоотой зардал	м.төг	67,605.2	-	-	#DIV/0!	-	
30	30 жилийн ойг угтах ажил	м.төг	-	300,000.0	69,431.0	23.1	(230,569.0)	
31	30 жилийн ойн зардал	м.төг	-	100,000.0	147,910.3	147.9	47,910.3	
32	Техникийн ББ-ийг хангах зардал	м.төг	-	700,000.0	-	-	(700,000.0)	
Өөрийн өртөг			м.төг	59,913,179.8	60,147,369.4	58,080,702.0	96.6	(2,066,667.5)
33	Удирдлагын зардал	Цалин хөлс	м.төг	420,726.3	525,105.1	517,148.1	98.5	(7,957.0)
		ЭМНДШ	м.төг	58,901.7	73,514.7	64,989.1	88.4	(8,525.6)
		Шатахуун, тос үйлчилгээ	м.төг	24,640.0	17,100.0	20,519.3	120.0	3,419.3
		ГУЗ-ийн зардал	м.төг	44,790.5	143,030.0	145,854.3	102.0	2,824.3
34	Нийт зардал болон дундаж өртгөөр тооцсон ББ-ийн зөрүү	м.төг	447,619.4	-	(216,910.2)	#DIV/0!	(216,910.2)	
Борлуулалтын өөрийн өртөг			м.төг	60,909,857.6	60,906,119.3	58,612,302.5	96.2	(2,293,816.7)

Үйл ажиллагааны бус зардал: Тус зардал 9.7 хувь буюу 169.6 сая төгрөгийн бууралттай гарсан шалтгаан нь “COVID-19” цар тахал гарч нийгэм соёлын арга хэмжээнүүд цуцлагдсантай холбоотой байна.

ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЛААР

2020 онд бизнес төлөвлөгөөгөөр нийт 57,941.3 сая төгрөгийн орлого олж 62,660.2 сая төгрөгийн зардал гарган 4,718.9 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр нийт 57,892.5

сая төгрөгийн орлого олж 60,196.8 сая төгрөгийн зардал гаргаж 2,304.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллалаа. Төлөвлөгөөт алдагдал 2.4 тэрбум төгрөгөөр буурсан шалтгаан нь борлуулалтын орлого 45.9 сая төгрөгөөр тасарсантай, уулын ажлын бууралттай холбоотойгоор төлөвлөгөөт зардал 2.3 тэрбум төгрөгөөр буурсантай холбоотой.

Д/д	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2019 гүйцэтгэл	2020 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%	Зөрүү
Б. Орлого, зардал, ашгийн үзүүлэлт							
1	Борлуулалтын орлого	м.төг	55,673,599.5	57,756,289.0	57,710,409.3	99.9	(45,879.7)
2	Борлуулалтын өөрийн өртөг	м.төг	60,909,857.6	60,906,119.3	58,612,302.5	96.2	(2,293,816.7)
3	Борлуулалтын ашиг (алдагдал)	м.төг	(5,236,258.1)	(3,149,830.3)	(901,893.2)	28.6	2,247,937.0
4	Үйл ажиллагааны бус орлого	м.төг	212,122.1	185,000.0	182,065.3	98.4	(2,934.7)
5	Үйл ажиллагааны бус зардал	м.төг	2,438,206.3	1,754,063.0	1,584,475.8	90.3	(169,587.2)
6	Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	м.төг	(2,226,084.2)	(1,569,063.0)	(1,402,410.5)	89.4	166,652.5
7	Татварын өмнөх ашиг	м.төг	(7,462,342.3)	(4,718,893.3)	(2,304,303.8)	48.8	2,414,589.5
8	ААНОАТ	м.төг	2,087.7	-	408.6	-	408.6
9	Татварын дараах ашиг	м.төг	(7,464,429.98)	(4,718,893.3)	(2,304,712.4)	48.8	2,414,180.9

Д/д	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2018 оны гүйцэтгэл	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	Харьцуулалт	
						%	төгрөгөөр
Б. Орлого, зардал, ашгийн үзүүлэлт							
1	Борлуулалтын орлого	м.төг	50,777,682.1	59,270,000.0	55,673,599.5	93.9	(3,596,400.5)
2	Үйл ажиллагааны бус орлого	м.төг	564,672.5	145,000.0	212,122.1	146.3	67,122.1
3	Нийт орлого	м.төг	51,342,354.6	59,415,000.0	55,885,721.6	94.1	(3,529,278.4)
4	Үйлдвэрлэлийн зардал	м.төг	52,659,259.9	54,425,861.6	60,909,857.6	111.9	6,483,996.0
5	Үйл ажиллагааны бус зардал	м.төг	1,311,534.1	1,628,471.4	2,438,206.3	149.7	809,734.9
6	Нийт зардал	м.төг	53,970,793.9	56,054,333.0	63,348,063.9	113.0	7,293,730.9
7	Татварын өмнөх ашиг	м.төг	(2,628,439.3)	3,360,667.0	(7,462,342.3)	(222.0)	(10,823,009.3)
8	ААНОАТ	м.төг	3,231.9	336,066.7	2,087.7	0.6	(333,979.0)
9	Татварын дараах ашиг	м.төг	(2,631,671.3)	3,024,600.3	(7,464,429.9)	(246.8)	(10,489,030.2)

Авлагын талаар

Компанийн нийт авлага 6031,8 сая төгрөг болж оны эхнээс 20.2 хувиар буюу 1530,7 сая төгрөгөөр буурсан. Авлагын 84 хувийг “ДЦС-4” ТӨХК-аас авах авлага, 11 хувийг бусад төрийн болон орон нутгийн өмчит ДС-уудаас авах авлага эзэлж байна. Шүүхийн шийдвэр гарсан боловч хэрэгжээгүйгээс үүдсэн авлага 320,1 сая буюу нийт авлагын 5 хувийг эзэлж байна.

Нүүрс борлуулалтын зах зээлээ өргөжүүлж борлуулалтаа нэмэгдүүлэх зорилгоор “Хөтлийн ЦШУ”, “Сэлэнгэ зүүнхараа” ОНӨААТҮГ, Сайншанд болон Булганы дулааны станцууд зэрэг хэрэглэгчидэд нүүрс нийлүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Эдгээр авлагууд хугацаандаа төлөгдөөд явж байна.

“ДЦС” ТӨХК-д нийлүүлэгдээд илчлэг нь тэнцэлгүй гологдсон нүүрсийг “Алхагч ЭШ” ХХК, “Элбэг дулаан” ХХК зэрэг компаниудад нийлүүлсэн бөгөөд эргэн төлөгдөх төлбөр нь удаашралтай байна.

Авлагын үлдэгдэл өөрчлөлт

Д/д	Харилцагчийн нэр	Оны эхний авлага	Оны эцсийн авлага	Буурсан	Өссөн
1	Сэлэнгэ Энерго ОНӨУГазар	841,403,998.00	775,807,996.00	(65,596,002.00)	
2	Улаанбаатар ТЭЦ-4	1,271,992,680.64	666,877,370.48	(605,115,310.16)	
3	ЦЕМЕНТ ШОХОЙ ХХК	604,655,787.86	568,000,000.00	(36,655,787.86)	
4	Хөтөл энержи дулаан ХХК	840,120,702.87	525,000,000.00	(315,120,702.87)	

5	Амгалан ДСтанц ХХК	394,914,050.00	473,821,071.84		78,907,021.84
6	ЭНЕРЖИ ПЛАС ХХК	310,359,886.00	343,346,544.00		32,986,658.00
7	Сэлэнгэ тэнгэр хараа ХХК	342,321,957.00	342,321,957.00		-
8	Энэрэлт Ээж ХХК	248,815,671.00	248,815,671.00		-
9	Налайх дулааны станц ТӨХК	446,122,879.98	223,000,000.00	(223,122,879.98)	
10	Бор Өндөрийн үйлдвэр	335,173,928.40	206,566,621.40	(128,607,307.00)	
11	Илчлэг Шивээ ОНӨҮГ	55,206,805.99	115,979,216.01		60,772,410.02
12	Чандмань илч ХХК Дорноговь	219,883,487.00	89,000,000.00	(130,883,487.00)	
13	УБТЗ ХНН	236,437.20	76,450,639.90		76,214,202.70
14	Сэлэнгэ-Зүүнхараа ОНӨҮГ /Мандал энерго /	50,527,438.55	72,136,240.00		21,608,801.45
15	Ус-Ду ОНӨААТҮГ	-	70,930,066.10		70,930,066.10
16	Бусад харилцагч /нүүрс/	915,574,449.40	593,720,939.38	(321,853,510.02)	
Нийт нүүрсний авлага		6,877,310,159.89	5,391,774,333.11	(1,826,954,986.89)	341,419,160.11

Авлага

Д/д	Харилцагчийн нэр	Оны эхний авлага	Оны эцсийн авлага	Буурсан	Өссөн
1	Нүүрсний авлага	6,877,310,159.89	5,391,774,333.11	(1,826,954,986.89)	341,419,160.11
2	Байгууллагаас авах авлага	370,578,521.76	279,228,525.13	(91,349,996.63)	
3	Ажилчдаас авах авлага	97,099,438.57	57,883,926.95	(39,215,511.62)	
4	Хувь хүмүүсээс авах авлага	86,144,596.65	84,439,471.47	(1,705,125.18)	
5	Бусад тооцооны авлага	30,770,236.80	130,770,236.80		100,000,000.00
6	Байрны авлага	100,752,441.31	87,765,941.31	(12,986,500.00)	
	Нийт авлага	7,562,655,394.98	6,031,862,434.77	(1,972,212,120.32)	441,419,160.11
	Найдваргүй авлагын ноц	(3,191,012,968.00)	(3,191,012,968.00)		

Богино хугацаат өр төлбөрийн талаар

Богино хугацаат өглөгийн хэмжээ 52212,1 сая төгрөг болж оны эхнээс 1.4 хувиар буюу 730.1 сая төгрөгөөр өссөн. Урт хугацаат өр төлбөрийн хэмжээ 75744,4 сая төгрөг болж оны эхнээс 0.6 хувиар буюу 486,8 сая төгрөгөөр буурсан. Нийт өглөг оны эхнээс 243.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн хомсдолоос шалтгаалан Сангийн яаманд төлөх зээлийн хүүгийн өглөг 767.6 сая төгрөгөөр, Нийт зардлын 1-н хувиар менежментийн төлбөр төлөхөөр тооцсоноос толгой компанид /Эрдэнэс Монгол ХХК/ төлөх өглөг 1343.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Урт хугацаат өглөг

Д/д	Өглөгийн төрөл	2020.01.01	2020.12.31	Өсөлт	Бууралт
1	Сангийн яам	61,792,724,679.07	62,035,544,089.39	242,819,410.32	
	Юнайтед Белаз Машинери ХХК	12,489,553,694.38	12,409,553,694.38		(80,000,000.00)

	Транс Техно Маркет	371,935,660.80	-		(371,935,660.80)
	Хойшлогдсон татварын өглөг	358,564,643.00	358,564,643.00	-	-
	Ажилчдын тэтгэвэрийн сан	1,218,522,661.73	940,762,661.73		(277,760,000.00)
	Урт хугацаат өглөгийн дүн	76,231,301,338.98	75,744,425,088.50	242,819,410.32	(729,695,660.80)

Богино хугацаат өглөг

Д/д	Өглөгийн төрөл	2020.01.01	2020.12.31	Өсөлт	Бууралт	
1	МОНР4,МОНР5 зээлийн хүүгийн өглөг	6,535,984,662.02	7,303,638,322.72	767,653,660.70		
2	Голомт банкны зээл	2,300,000,000.00	-		(2,300,000,000.00)	
3	Эрдэнэс Монгол ХХК-ийн зээл	5,500,000,000.00	5,400,000,000.00		(100,000,000.00)	
4	Эрдэнэс Монгол ХХК-д төлөх лицензийн төлбөр	9,374,645,998.64	10,717,786,827.91	1,343,140,829.27		
5	Санхүүгийн түрээс	Тэнгэр суудал ХХК	2,447,000,000.00	-		(2,447,000,000.00)
		Вагнер Ази ТТ ХХК	2,584,000,000.00	-		(2,584,000,000.00)
		ДБМ лизинг ХХК	1,066,895,190.91	936,881,892.40		(130,013,298.51)
6	Байгууллагуудын өр	10,507,370,840.89	7,594,290,730.79		(2,913,080,110.10)	
7	Татварын өглөг	6,990,027,667.37	10,129,621,951.80	3,139,594,284.43		
8	НДШ-ийн өглөг	3,263,452,148.55	5,508,113,895.80	2,244,661,747.25		
9	Цалингийн өглөг	847,157,177.00	971,585,743.00	124,428,566.00		
10	Ногдол ашгийн өглөг	13,041,910.10	13,041,910.10	-	-	
11	Урьдчилж орсон орлого	52,523,979.42	17,218,516.06		(35,305,463.36)	
12	Богино хугацаат зээл		3,620,000,000.00	3,620,000,000.00		
	Богино хугацаат өглөгийн дүн	51,482,099,574.90	52,212,179,790.58	11,239,479,087.65	(10,509,398,871.97)	

Нийт өглөгийн дүн	127,713,400,913.88	127,956,604,879.08	11,482,298,497.97	(11,239,094,532.77)
--------------------------	---------------------------	---------------------------	--------------------------	----------------------------

2020 онд Худалдан авалтын төлөвлөгөөг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан ажиллалаа.

“Шивээ Овоо” ХК-ийн худалдан авалтын төлөвлөгөөг 2020 оны 02 дугаар сарын 3-ны өдөр батлуулсан, 3 удаа тодотгол хийгдсэн. Үүнд, 223 нэр төрлийн сэлбэг бараа материал, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн. Гүйцэтгэх захирлын тушаалаар 3 нээлттэй тендерийн үнэлгээний хороо, 4 харьцуулалтын үнэлгээний хороо байгуулагдан ажилласан.

Энэ онд нийт 29,6 тэрбум төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулж ажиллалаа. Мөн эрх шилжүүлэх тендерийг “Эрдэнэс Монгол” ХХК зохион байгуулан ажилласан ч манай компани өөрийн үйл ажиллагааны орлогоор эргэн төлөх “JBIC” зээлийн гэрээгээр 14,7 тэрбум төгрөгийн техникүүдийг тооцвол дээрх дүн 44,3 тэрбум болж байна. Энэ онд дэлхий нийтийг хамарсан “COVID-19” цар тахал тархаж үйлдвэрлэгч орнуудаас импортоор орж ирэх барааны нийлүүлэлт буурсан ч Худалдаа хангамжийн алба хууль дүрэм журамд нийцүүлэн худалдан авах тендерүүд болон өдөр тутмын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж ирсэн.

2020 онд доорх худалдан авалтыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалт 6 төрлөөр - 15,9 тэрбум
- Харьцуулалтын тендер шалгаруулалт 5 төрлөөр - 1,4 тэрбум

- ШХА - 2661 нэр төрлийн сэлбэг бараа материал захиалснаас 1928 буюу 72,5 хувийн худалдан авалтыг зохион байгуулж - 3 тэрбум
- Түлш - 8,3 тэрбум

Нийт **29,6 тэрбум**

2018-2020 онуудад хийгдсэн удаа дараагийн хяналт шалгалтуудад Санхүү, Худалдаа хангамжийн алба амжилттай орж дүгнүүлсэн.

Тухайлбал Эрчим хүчний яам, ЗГХЭГ, Уул уурхайн яам, “Эрдэнэс Монгол” ХК хамтарсан ажлын хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын ажлын хэсэг, Үндэсний Аудитын газрын ажлын хэсэг зэрэг байгууллагуудаас явцын дараалсан шалгалтуудад холбогдох баримт бичгийн болон зохион байгуулалтын ажлыг амжилттай зохион байгуулж шалгалтын үр дүнгүүд хангалттай гэсэн үнэлгээтэй гарсан.

2020 онд Уул уурхай хүнд, үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайд нарын хамтарсан тушаалаар “Шивээ овоо” ХК-ийн санхүү, худалдаа хангамжийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж дүгнэлт өгөх ажлын хэсгийн шалгалтаар санхүү, худалдаа, хангамжийн үндсэн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг хангалттай сайн байна гэсэн дүгнэлт гаргасан.

ДӨРӨВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

“Шивээ Овоо” ХК нь 2018 оны 9 сараас дараах бүтэцтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан тэргүүн дэд захирал, Бизнес хөгжил хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал, Ерөнхий инженер болон 5 хэлтэс, 4 алба, 8 хэсэг, Улаанбаатар төлөөлөгчийн газар гэсэн бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Удирдлагын нарядын талаар: Тус онд компанийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд өдөр болгон 15.00 цагт үйлдвэрлэлийн шуурхай наряд, 7 хоног бүрийн 1 дэх өдөр Гүйцэтгэх захирлын нэгдсэн наряд зохион байгуулж, сар, 7 хоногийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэлэлцэж, ажлын тодорхой чиглэл, үүрэг даалгаврыг өгч ирсэн байна. Өнгөрсөн онд Захирлын зөвлөлийн гишүүд, ерөнхий мэргэжилтнүүд, алба, хэсгийн дарга нар, нэгжүүдэд нийт 2974 наряд өгөгдсөн, биелэлт 92% хувийн биелэлттэй гүйцэтгэсэн байна.

Компанийн Захирлын зөвлөлийн хурлыг 23 удаа хуралдаж нийт 276 асуудал хэлэлцэхээс 275 асуудал хэлэлцэн 99,6% гүйцэтгэлтэй ажилласан.

2020 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 чиглэлийн нийт 377 чиг үүргийн ажил, үйлчилгээ төлөвлөсөнөөс 100 хувийн гүйцэтгэлтэй 330 ажил, 50-70 хувийн гүйцэтгэлтэй 47 ажил байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 93.1 хувьтай байна.

Техникийн комиссын хурал 2020 онд 9 хүний бүрэлдэхүүнтэй 10 удаа хуралдаж, нийт 423 акт хэлэлцэж, цаашид авах арга хэмжээ, шийдвэрүүдийг гаргаж ажилласан байна.

Өмч хамгаалах зөвлөл нь 2020 онд нийт 3 удаа хуралдсан байна. Хурлаас өмч хамгаалах талаар 16 шийдвэр гарч, хэрэгжилтийг ханган ажиллав.

Шивээ-Овоогийн уурхай нь 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үйл ажиллагаагаа 559 ажилтантайгаар байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээ, түр ажлын байранд хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс эмэгтэй 105 ажилтан. Удирдах ажилтан

11, инженер техникийн ажилтан 131 байна. -Үндсэн үйлдвэрлэл 362, гүйцэтгэх 138 ажилтан, үйлчилгээний 59 ажилтантайгаар үйл ажиллагаа гүйцэтгэж байна.

Ажилтнуудын насны байдлыг харуулахад:

№	Нас	Тоо		Нийт	Хувь
		Эрэгтэй	Эмэгтэй		
1.	18-25	66	3	69	12%
2.	26-35	182	37	219	39%
3.	36-45	117	38	155	28%
4.	45-аас дээш	89	27	116	21%
Нийт		454	105	559	100%

Ажилтнуудын дундаж нас: 37 нас

Хүйсийн байдлаар нь авч үзвэл:

№	Хүйс	Тоо	Хувь
1.	Эрэгтэй	454	81%
2.	Эмэгтэй	105	19%

Боловсролын түвшинээр нь авч үзвэл:

№	Ангилал	Тоо	Хувь%
1.	Боловсролгүй	6	1
2.	Бага боловсролтой	7	1
3.	Суурь боловсролтой	19	4
4.	Бүрэн дунд	20	4
5.	Мэргэжлийн болон техникийн	308	55
6.	Дээд	Дипломын-27	35
7.		Бакалавр-160	
8.		Магистр-12	
Нийт		559	100%

Зөвлөх инженер-1

Мэргэшсэн инженер-6

АЖИЛТНУУДЫН ТОГТВОР СУУРЬШИЛ, АЖИЛЛАСАН ЖИЛ:

№	Ажилласан жил	Тоо	Хувь
1.	1 – 4	248	44
2.	5 – 10	149	27
3.	11- 15	80	14
4.	16 – 20	61	11
5.	21-ээс дээш жил	21	4
Нийт		559	100%

2020 онд гадны байгууллагаас 542 албан бичиг ирж, бүртгэл үйлдэн, Гүйцэтгэх захиралд танилцуулан холбогдох албан тушаалтанд бүртгэлийн дагуу хүлээлгэн өгсөн. Эрх бүхий дээд байгууллагаас нийт 135 албан бичиг ирсэн байна. Компаниас нийт 1110 албан бичиг явуулсан ба хариутай 57 албан бичгийг нь хугацаанд нь хүргүүлсэн болно. Гүйцэтгэх захирлын А тушаал-172, Б тушаал-559 тушаалын төслийг хүлээн авч хэвлэмэл хуудсанд хэвлэж он сарын дарааллаар

дугаарлаж, бүртгэлийг хөтөлсөн байна. Архивын тасаг Гүйцэтгэх захирлын 1990-2019 оны нийт 11280 тушаалыг скайнердан файл болгон хадгалсан.

Нийт ажилчид, иргэдээс тухайн 329 өргөдөл хүлээн авч, 321 өргөдөл буюу 97.5 % гүйцэтгэлтэйгээр хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна. 8 өргөдөл нөөцөд бүртгэлтэй байна. Ирсэн өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Өргөдлийн ихэнхи нь ажил хүссэн, ажлын байр солих, хүүхэд асрах чөлөө хүссэн байсан.

Энэ онд шинээр 94 иргэнийг ажилд авч, хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Нийт 149 иргэн ажил горилж анкет өгсөн байна. Боловсролоор нь ангилж авч үзвэл дээд боловсролтой иргэн 30 буюу 44.7% эзэлж байна. Сум, орон нутгаас нийт 85 ажилтныг ажлын байраар ханган ажиллуулсан байна. /Говьсүмбэр аймаг-10, Шивээговь сум-74, Баянтал сум-1/. Үүнээс эмэгтэй-18, эрэгтэй-67.

Хүний нөөцийн бүрдүүлэлтийн 95 хувийг аймаг, сум орон нутгаас сонгон авч ажиллуулснаар компанийн тогтвортой байдлын коэффициент 98 хувь болж өмнөх оноос өссөн үзүүлэлтэй гарсан. Хүний нөөцийн бодлогын баримт бичигт тусгагдсаны дагуу “Карьер өсөлтийн төлөвлөгөө” боловсруулан хэрэгжүүлж дээрх ажлын хүрээнд нийт 15 ажилтан албан тушаал дэвшин ажилласан байна.

Бид хүний нөөцийн бүрдүүлэлтийг Говьсүмбэр аймаг дахь Уул уурхайн жишиг Политехникийн коллеж, уул уурхайн чиглэлийн их дээд сургууль, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран ажиллахаас гадна дотоод эх үүсвэр болон ажил горилогчдоос бүрдүүлэлт хийн ажиллаж байна.

2020 онд ажилд орсон, гарсан мэдээллийг хүснэгтээр харуулав.

Үзүүлэлтүүд	Улирал				Нийт
	I	II	III	IV	
Оны эхэнд бүртгэлтэй ажилтнуудын тоо	553	553	564	557	553
Шинээр ажилд орсон	17	32	20	29	98
Анкетын сонгон шалгаруулалт	13	19	17	26	75
Ур чадварын сонгон шалгаруулалт	3	4	2	-	9
Нөөц					-
Сонгогдсон	1	1	1	3	6
Бусад		8			8
Хөдөлмөрийн гэрээ цуцалсан	17	21	27	27	92
Өөрийн хүсэлтээр	9	8	9	14	40
Хөлсөөр ажиллах гэрээ болон Хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан	1	5	8	7	21
Өндөр насны тэтгэвэрт	1	1	4		6
Цэрэг татлага				3	3

Сахилгын шийтгэлээр	5	7	5	2	19
Орон тоо хасагдсан				1	1
Бусад	1	-	1		2
Оны төгсгөлд бүртгэлтэй ажилтны тоо	553	564	557	559	559

Хүний нөөцийн коэффициентуудыг харцуулан харуулбал:

Үзүүлэлт	Улирал				Нийт
	I	II	III	IV	
Хүний нөөцийн оролтын байдал	3,06%	5,5%	3,6%	5,1%	18%
Хүний нөөцийн гаралтын байдал	2,7%	3,6%	4,8%	4,8%	16%
Хүний нөөцийн тогтворгүй байдал	2,4%	2,6%	3%	3%	11%
Хүний нөөцийн тогтворжилтын байдал	97%	96%	95%	95%	98%

Хэсэг нэгжийн ажилтнуудыг дотооддоо сургах сургалтад нийт давхардсан тоогоор 301 ажилтанд 508 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Хүний хөгжлийг дэмжих ажлын зардал нь 1724.1 төлөвлөж, гүйцэтгэлээр 619.0 төгрөг болсон байна. Нийгмийн хамгааллын зардалд 1286,6 сая.төг төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 489,8 сая.төгрөг буюу 38%-тай байна. Компаний харьяа спорт клубын тамирчид улс, бүсийн тэмцээнээс 88 медаль хүртсэн байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 5/98 дугаар албан бичгээр өгсөн зөвлөмжийн дагуу “Шивээ-Овоо” ХК 2018-2023 он хүртэл мөрдөх “Шивээ-Овоо” ХК-ийн “Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө”-г боловсруулан баталсан. “Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө” батлагдсаны дагуу “Хүний нөөцийн бодлого” болон бусад баримт бичгийг боловсруулан мөрдөж байна.

Авилгын эсрэг тайлан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тайланг цаг хугацаанд нь гаргаж, холбогдох газруудад хүргүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Прокурорын газартай хамтарч “Авлига, түүний тухай ойлголт”, авлигын мөн чанар хор уршиг эрүүгийн хуульд заасан ял шийтгэлийн талаар” сургалтыг цахим сүлжээгээр зохион байгуулсан.

Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг авилгын эсрэг, түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль, дүрэм журмын дагуу гаргуулан “Эрдэнэс Монгол” ХХК, “Авилгатай тэмцэх газар”-т 2020.02.01-ны өдөр хүргүүлсэн. Шинэ ажилтнуудад дээрх хуулийн талаарх зааварчилга, мэдээллийг өгч ажилласан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2016, 2017 онуудад тус компанид өгсөн зөвлөмжүүдийн тайланг хүргүүлэн ажиллалаа.

2020 онд компанийн 30 жилийн ойн хүрээнд бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг дотоод нөөц бололцоогоороо хийж гүйцэтгэлээ. Үүнд хэсэг, нэгжийн конторын дотор, гадаад засвар, тохижилтын ажилд 147,5 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь ажилтан, албан хаагчдын ажил, үүргээ гүйцэтгэхэд тохилог, таатай орчинг бүрдүүлсэн байна.

Компанийн цахим мэдээллийн сайтыг шинэчилж /www.shivee-ovoo.mn/ ажиллуулж, уурхайн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг "Shivee-Ovoo" Joint stock company фэйсбүүк /3,480 дагагчтай/, “Шивээ-Овоо” ХК Хүний нөөцийн алба /1623 дагагчтай/ фэйсбүүк хаягаар байршуулсаар байна.

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ:

Байгууллагын хэмжээнд 2020 онд удирдлага, ажилтнуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд “Эхлээд аюулгүй ажиллагаа” зарчмыг баримтлан ажилласан.

Ажлын байрны эрсдэлийг удирдах, хяналтыг тогтоож, ажилтнуудад ХАБЭА-н зөв зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааны чиглэлээр 41 ажил, ХАБЭА-н хяналтын чиглэлээр 20, Эмнэлгийн тусламж үйлчилгээ, эрүүл ахуйн чиглэлээр 19, ХАБЭА-н сургалтын чиглэлээр 20, удирдлагын тогтолцоо, менежментийн чиглэлээр 7 ажил, нийт 107 ажил төлөвлөн хэрэгжүүлсэн ба гүйцэтгэл 83,5% байна.

Ажлын гүйцэтгэл дутуу байгаа нь 2020 онд Монгол улсын хэмжээнд хөл хорио тогтоосон, COVID-19 вирусын халдвар тархсантай холбоотой хийгдээгүй, олон нийтийн болон сургалтын ажлууд байна.

№	Төлөвлөсөн ажил	Тоо	Бүрэн гүйцэтгэлтэй	Дутуу гүйцэтгэл	Тайлбар
1	ХАБЭА-н үйл ажиллагааны чиглэлээр	41	34	7	6 ажил “КОВИД-19”-тэй холбоотой хойшилсон
2	ХАБЭА-н хяналтын чиглэлээр	20	20	0	100% хийгдсэн
3	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эрүүл ахуйн чиглэлээр	19	16	3	1 ажил “КОВИД-19”-тэй холбоотой хойшилсон
4	ХАБЭА-н сургалтын чиглэлээр	20	10	10	10 ажил “КОВИД-19”-тэй холбоотой хойшилсон
5	ХАБЭА-н удирдлагын тогтолцооны чиглэлээр	7	3,5	3,5	
	НИЙТ гүйцэтгэл 83,5%	107	83,5		

“Эрүүл уурхайчин” хөтөлбөр:

“Эрүүл уурхайчин” хөтөлбөрийг боловсруулан 453 ажилтнуудын зонхилон тохиолдох өвчлөлийн судалгаа гаргаж хэт таргалалтаас урьдчилан сэргийлэх, эрүүл зөв хооллолт, хөдөлгөөн эрүүл мэнд, зүрх судас, артерийн даралт ихсэх өвчлөлөөс урьдчилан сэргийлэх аяныг 1, 7, 8, 12-р саруудад зохион байгуулсан.

Амьдралын зөв дадал зуршил, эрүүл зөв хооллолт, архи, тамхины хэрэглээ, дам тамхидалтын сургалтыг тогтмол зохион байгуулснаар артерийн даралт ихсэх өвчнөөр ажлаас буусан ажилтнуудын тоо буурсан.

1, 12 дугаар саруудад “Хөдөлгөөн эрүүл мэнд” уриан доор нийт ажилтнуудыг дасгал хөдөлгөөн хийлгэх ажлыг спорт зааланд хуваарь гарган мэргэжлийн багшаар хийлгэсэн ба хөл хорио, covid-19 вирусын халдварын үед онлайнаар зохион байгуулан ажилтнуудыг идэвхитэй хамруулж байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ, эрүүл ахуйн чиглэлээр:

Нийт ажилтнуудыг мэргэжлээс шалтгаалах өвчлөл, халдварт өвчин болон ердийн өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг Мэргэжлийн өвчин судлалын газар, Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран зохион байгуулсны дагуу илэрсэн зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулах, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулан нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээ, сувилалд хамруулан ажиллаж байна.

ХАБЭА-н хяналтын чиглэлээр:

ХАБЭА-н хяналтын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг, шалгалтыг ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, галын аюулгүй байдал, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн технологийн болон техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал зэрэг чиглэл тус бүрээр бүх ажлын байруудад зохион байгуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж байна.

ХАБЭА-н сургалт:

Байгууллагын хувьд ажилтнуудын аюулгүй ажиллагааны арга барилыг сайжруулах, зөв зан үйлийг төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх гол зүйл бол аюулгүй ажиллагааны сургалт юм. 2020 онд дэлхий даяар халдварт өвчин гарч хорио цээрийн дэглэмд шилжсэн хэдий ч нөөц, боломжоо ашиглан аюулгүй ажиллагааны чухал шаардлагатай сургалтуудыг зохион байгуулж ажилласан.

ХАБЭА-н нийт ажилтны сургалтыг Covid-19 вирусын халдвар, хөл хорионы дэглэмийн үед зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан, хөл хорионы дэглэм буурсан үед танхимын хэлбэрээр, богиносгосон цагаар 2-5-р саруудад зохин байгуулсан.

ХАБЭА-н бусад төрлийн сургалтуудыг онлайн хэлбэрээр болон цөөн тоогоор хүн хоорондын зайг баримтлуулан халдвар, хамгааллын дэглэм баримтлан зохион байгуулсан.

“COVID-19” цар тахал, вирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Монгол Улсад халдвар илэрснээс хойш уурхайн үйлдвэрлэлийг хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор үүссэн нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөгөө, заавар, зарцуулагдах хөрөнгийг батлан шуурхай удирдлагын штабыг томилон ажиллаж байна.

Улсын Онцгой Комиссын тогтоолын дагуу манай байгууллага нь халдварын голомтгүй, гаднаас халдвар оруулахгүй байх зорилгоор “Аюулгүйн бүс” тогтоон ажиллаж байна. Аюулгүйн бүс тогтоон ажиллах үед зохион байгуулах ажлын төлөвлөгөө, заавруудыг Уул уурхай хүнд үйлдвэрийн гамшгаас хамгаалах шуурхай штабын зөвлөмжийн дагуу боловсруулан нийт ажилтнууддаа танилцуулсан. Дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Нийт ажилтнуудад батлагдсан зөв мэдээллийг ажлын байрны өдөр тутмын зааварчилгаа, байгууллагын сошиал сүлжээ, цаасаар гарган тогтмол танилцуулсан.
- Шуурхай зарлан мэдээлэх схемийг шинэчлэн гаргаж, албан тушаалтан, нийт ажилтнуудын үүрэг, оролцоог тусгасан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн.
- Ажилтнуудыг ажилд гарах, буух үед сууж явах автобусыг хуваарилан, ажилд гарах бүрд биеийн халууныг шалган, гарыг ариутгуулан, амны хаалтыг /маск/ шинээр олгож, хуучин амны хаалтыг зориулалтын уутанд хаяж, бүртгэл хөтлөн тээвэрлэж байна.
- Хүн тээврийн автобуснуудыг зорчигч тээвэрлэхийн өмнө буюу дараа нь тогтмол ариутгаж, цэвэрлэж байна.
- Ажилтнуудыг хоолонд орох цагт бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохион байгуулж цагийн хуваарь гарган, хоолонд орохын өмнө биеийн халууныг хэмжин гадуур хувцасыг тайлуулан, гарыг ариутгуулан хүн хоорондын зайг баримтлуулан хоолонд оруулж байна. Хоолны ширээ бүрд тусгаарлах хаалт хийн эрүүл ахуй, халдвар хамгаалалд хяналт тавьж ажилласан.
- “Маскаа зүүе, гараа угаая” аяныг уурхайн хэмжээнд зохион байгуулан нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.
- Байгууллагын санхүүжилтээр “COVID-19 “вирусын халдварыг илрүүлэх түргэвчилсэн оношлуурыг авч, шаардлагатай тохиолдолд шинжилгээг өөрийн яаралтай тусламжийн ээлжийн эмч нараар авахуулж бэлэн байдлыг ханган ажиллаж байна.